



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор Тохижилт Үйлчилгээ ОНТҮГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/72/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР ТОХИЖИЛТ 7
ҮЙЛЧИЛГЭЭ ОНТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ЦЭДЭНДАМБАА
ТАНАА

2020.02.27 № 1/234

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

005020272

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын захирал Г.Цэдэндамбаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор Тохижилт үйлчилгээ 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго "Баянхонгор хотыг орчин үеийн залуу, ногоон хот болгож, Дархан Эрдэнэт хотуудын жишигт хүргэх"-д оршино.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ
- Хот тохижилт, цэцэрлэгжилт түүний өргөтгөл шинэтгэл, арчилгаа
- Хот доторх ногоон байгууламж, цэцгийн мандлын арчилгаа, үйлчилгээ
- Үерийн хамгаалалтын даланг засварлаж хөрсний элэгдэлтэй тэмцэх
- Мод үржүүлэг, ойжуулалт
- Төвлөрсөн системтэй холбогдсон нийтийн бие засах газар
- Хот доторх нийтийн эзэмшлийн хөшөө, түүх соёлын дурсгалт зүйлсийн арчилгаа, засвар үйлчилгээ
- Паркуудын ашиглалт хамгаалалт, засвар үйлчилгээ

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1587556.7 мянган төгрөгөөс тооцон 15875,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 305725.9 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	364.72		-364.72
Авлага	468.6	6266.5	5797.9
Бараа материал	80951.8	295962.0	215010.2
Үндсэн хөрөнгө	10936902.4	11888422.3	951519.9
Хуримтлагдсан элэгдэл	-3586906.5	-4453143.8	-866237.4
Нийт хөрөнгө	7431781.0	7737506.9	305725.9
Өр төлбөр	19520.4	9042.6	-10477.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7412260.6	7728464.3	316203.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7431781.0	7737506.9	305725.9

Мөнгөн хөрөнгийн дансанд 364,7 мянган төгрөг байсан ба оны эцэст үлдэгдэлгүй байна

Авлага дансны үлдэгдэл 5797,9 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдын орон сууцны зураг төсвийн үнэ 6111,4 мянган төгрөгийг шилжүүлснээс шалтгаалжээ. Мөн авлагын дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн цалингийн урьдчилгааны үлдэгдэл 155,0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 215010,2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал 47462,9 мянга, давс 5000,0 мянга, дуусаагүй үйлдвэрлэл /ажилчдын хувцас/ 6679,5 мянга, бичиг хэргийн материал 608,0 мянга, аж ахуйн материал 19576,4 мянга, барилгын засвар 21556,0 мянга, бусад хангамжийн материал 121838,9 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Тусгай зориулалттай материал 47462,9 мянган төгрөгөөр өссөн нь усалгааны систем 48480,0 мянган төгрөгөөр орлого авсантай холбоотой байна. Дуусаагүй үйлдвэрлэлд ажилчдын нормын хувцас бүртгэдэг ба тухайн тайлант хугацаанд 10395,0 мянган төгрөгийн ажилчдын хувцас орлого авсан байна. Аж ахуйн материалд нийтийн эзэмшлийн зам талбай, байгууламжуудыг засварлах нөхөн сэргээх зориулалттай материалуудыг энэ дансанд бүртгэдэг ба тухайн онд 44509,3 мянган төгрөгийн орлого авч 24932,9 мянган төгрөгийн зарлага гаргасан байна. Тухайн тайлант хугацаанд тус байгууллага нь мазаалай паркад байрлах сүүдрэвч, сандал, шат, хөшөө, баримал зэргийг будаж өнгийг сэргээсэн, мөн усан оргилуурын гэрэлтүүлэг, хошуунуудыг сольж хэвийн болгосон, янгиртай хөшөөний урсгал засварыг хийж ажиллахгүй байсан усан хөшгийг ажиллуулсан, "Гурван бүс" цогцолборын явган зам, замын бродюр, сандал сүүдрэвч зэрэгт урсгал засвар хийсэн.

“Эрдэнэмандал” хайрханы шатны хэсгийг шохойдож, бурхан, хашлага, хашаа хэсэг, гэрэлтүүлгийн шон зэргийг будаж засварласан, Гандангийн өмнөх талбайн сүүдрэвчнүүдийн мод, цэцгийн мандлын суудаг сандал, хашлага зэргийг бүрэн сэргээн засварласан байна. Барилгын засварын материал 21556,0 мянган төгрөгөөр өссөн нь тухайн тайлант хугацаанд 31800,0 мянган төгрөгийн материал орлого авч 10244,0 мянган төгрөгийн зарлага гаргасан байна. Үүнд замын дагуух хайс, шонгийн засварын материалыг орлого авч зардал гаргасан байна. Бусад хангамжийн материал 121838,9 мянган төгрөгөөр өссөн нь Байгал орчин аялал жуулчлалын газраас зүлэгний үр, усалгааны материал, цэцгийн мандал, хайлаас мод 73700,0 мянган төгрөгөөс үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, “Бөмбөгөр хайрхны төгөл” ХХК-аас буйлс, гүйлс, улайс, хайлаас, зүлэгний үр 50000,0 мянга, “Дааган дэлийн Эх” ХХК-аас бор шороо 10000,0 мянга, “Оюунлаг хонгорчууд” ХХК-аас хайлаас мод 10000,0 мянга, “Цэсүэрэ” ХХК-аас бусад хангамжийн материал 15044,0 мянган төгрөг тус тус орлого авсан байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 951519,9 мянган төгрөгөөр өссөн нь Үндсэн хөрөнгөнд тухайн онд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.12.25-нд 122 дугаар тогтоолоор Nissan Advan маркийн автомашин 9594,0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн зам талбай 574512,8 мянган төгрөг, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.01.31-ны өдрийн 17 дугаар тогтоолоор мазаалай цэцэрлэгт хүрээлэнгийн нуурын усыг сэлгэх байгууламж 59800,0 мянган төгрөг, аймгийн хатуу хучилттай автозамын засвар капиталжуулах 39988,8 мянган төгрөг, Аймгийн ИТХ-ын 2019.12.25-ны өдрийн 126 дугаар тогтоолоор Ламын гэгээний түмэн өлзий гийсний 380 ойн хандиваар авсан 13900,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд тус тус орлогодсон байна. Мөн Аймгийн ИТХ-ын 2019.03.19-ны өдрийн 41 дугаар тогтоолоор Цагдаагийн газрын хөрөнгөнд бүртгэлтэй гэрлэн дохио 241985,6 мянган төгрөг, Аймгийн ИТХ-ын 2019.06.13-ны өдрийн 70 дугаар тогтоолоор Баянхонгор Эрчим хүч цахилгаан түгээх ХХК-аас 18500,0 мянган төгрөгийн өртөг бүхий өргөгч краныг балансаас баланст шилжүүлэн авсан байна.

Мөн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 131 дугаар тогтоолоор тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгөнөөс 35923,4 мянган төгрөг, аймгийн ИТХ-ын 18 дугаар тогтоолоор 32000,0 мянган төгрөгийн ковш, Аймгийн ИТХ-ын 2019 оны 10 сарын 24-ны өдрийн 102 дугаар тогтоолоор 20000,0 мянган төгрөгийн өртөгтэй Прадо маркийн автомашин, тус тус акталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019.01.31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор Сум дундын ойн ангид 105689,7 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10477,7 мянган төгрөгөөр буурсан нь урд онд гэрэл цахилгаанд 19434,5 мянган төгрөгийн өртэй байсан ба үүнийг барагдуулсантай холбоотой байна. Мөн тухайн онд 4,5 багийн багийн шороон замыг тэгшлэх замын санхүүжилтийн үлдэгдлийг 12 сард шилжүүлсэн боловч нэр данс зөрүүтэй орлого гэж буцаж орж ирсэнтэй холбоотой 8816,7 мянган төгрөгийн өглөг, 225,9 мянган төгрөгийн цалингийн өглөг шинээр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7728464,3 мянган төгрөг болж 316203,7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 296769,2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 19434,4 мянган төгрөгийн бичилт нь урд оны гэрэл цахилгааны өглөгийг 19434,4 мянган төгрөгийг хаасантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-аар тайлант онд 6000,0 мянган төгрөгийн өөрийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 12790,5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 213,2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	6000,0	12790,5	6790,5	213,2
Нийт дүн	6000,0	12790,5	6790,5	213,2

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Тохижилт үйлчилгээний хөтөлбөрт зориулан 637155,6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 637155,6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 564122.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 67033.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 6000,0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 637133,0 мянган төгрөг буюу 100 хувь зарцуулагдсан ба орон нутгийн төсвөөс 564104,3 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 67028,7 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 6000,0 мянган төгрөгөөр тус тус санхүүжиж орон нутгийн төсвөөс 17,6 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 4,9 мянга тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Байгал орчны газраас мод, цэцгийн мандал, усалгааны системийн ажлын үнэнд 35000,0 мянга, аймгийн ЗДТГ-аас Баянхонгор сумын 4,5 багийн шороон замыг тэгшлэх ажлын санхүүжилтэд 10000,0 мянга, туслах үйл ажиллагааны давсан орлого 6790,5 мянга, нийт 51790,5 мянган төгрөгийн орлого орж 43000,0 мянган төгрөгийг зарцуулан 8790,5 мянган төгрөгийг төвлөрүүлэн санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 8714,3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 8083,0 мянган төгрөгийн алдааг залруулж, 83,9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 544,4 мянган мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 628,3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 83,9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. "Монголын цахилгаан холбоо" ХХК руу 2019 оны 11 сарын 18-нд интернетийн төлбөр шилжүүлэхдээ нэхэмжилсэн дүнгээс 86,9 мянган төгрөгийн илүү шилжүүлж авлага үүсгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар дараах 8083,0 мянган төгрөгийн алдааг залруулж санхүүгийн тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Тайлант туслах үйл ажиллагааны орлогод 6000,0 мянган төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр үндсэн дансанд 12790,5 мянган төгрөг орж, Баянхонгор аймгийн Засаг даргын 2019.12.16-ны өдрийн А/652 дугаар захирамжаар төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах зөвшөөрөл олгосны дагуу давсан орлогын 6790,5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлж ажилчдын орон сууцны зургийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 2019.12.26-ны өдөр Алтанцэцэгт шилжүүлж, тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.27 Урьдчилж төлсөн төлбөрийг үүссэн тооцоо буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж бүртгэнэ гэсэн заалтыг зөрчсөн байна

1.2 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үрэгдэх, шавшигдах

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар тусгах

2. Балансын данстай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Тухайн байгууллагын урсгал засварын зардлаас Нэгдэлчин зочид буудлын уулзвараас Онцгой байдлын уулзвар хүртэл 1292,5 мянган төгрөгийн тусгаарлах хайс хийж тохижуулсан байна. Үүнийг тус байгууллага хөрөнгөндөө бүртгээгүй байна.

Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1 Эрсдэл

Төсвийн хөрөнгө үрэгдэх, шавшигдах

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн бараа материал тусгах

Аудитаар илэрсэн 544,4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засвар тохижилттой холбоотой хөрөнгө орлого авсан эсэх, авлага, өглөгийг санхүүгийн тайланд бүрэн тусгасан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор "Тохижилт үйлчилгээ" ОНТҮГазар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй /Хугацаа болоогүй/
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	93	3	

6 Нийт	27	151	146	5
--------	----	-----	-----	---

Бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс хугацаандаа байршуулсан 6 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Үүнд хугацаа хоцроосон 3 мэдээлэл нь:

- Байгууллагын батлагдсан төсөв
 - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
 - Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлсийн жагсаалт, гүйцэтгэл
- Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл:
- Санхүүгийн тайлан
 - Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт

Хагас жилээр байршуулах 4 мэдээллийг хугацаанд нь, сар бүр байршуулах 36 мэдээллийг хугацаанд нь, тухай бүр байршуулах 96 мэдээллээс 93 мэдээллийг хугацаанд 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Тухай бүр байршуулах хугацаа хоцроосон 3 мэдээлэл нь:

- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр /3,4,7 сар/

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эхний 468,5 мянган төгрөгийн авлагаас цалингийн урьдчилгааны 155,0 мянган төгрөгийг одоо болтол барагдаагүй байна. Үүнийг нягтлан бодогчоос тодруулахад ажлаас гарсан хүний цалингийн урьдчилгаа гэж хариулав.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчсөн байна

Эрсдэл:

Өглөг, авлагагүй ажиллах зарчмыг баримталж ажиллахгүй байх

1.2. Өгсөн зөвлөмж:

Цалингийн урьдчилгааны 155,0 мянган төгрөгийг барагдуулах ажлыг төсвийн менежер хариуцан барагдуулан цаашид авлага өглөггүй ажиллах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Цалингийн түүвэр хийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардалтай тулган шалгахад зөрүүгүй тохирч байна. ХАОАТ-ыг төлсөн дүнтэй шалгахад 2688,8 мянган зөрүүтэй гарсан нь өмнөх оны өр байна. НДШ-ийг НДШ мэдээ, төлсөн мөнгөн дүнтэй тулган шалгахад 389,4 мянган төгрөгийг НДШ-д дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам 16.1 “Энэ Хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна

2.2. Эрсдэл:

Цалин, НДС, ХАОАТ-ыг илүү дутуу тооцоолох

2.3. Өгсөн зөвлөмж:

Цалингийн программ ашиглан цалин, НДС, ХАОАТ-ыг тооцон сар бүр НДС, ХАОАТ-ыг төлж байх, өглөг авлага үүсгэхгүй ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>81,785,098.75</u>	<u>302,228,450.23</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	364,720.50	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	364,720.50	00.00
31110	Төгрөг	364,720.50	00.00
33	АВЛАГА	468,550.75	6,266,450.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	460,000.00	155,000.00
335	Бусад авлага	8,550.75	6,111,450.00
3351	Байгууллагаас авах авлага	8,550.75	6,111,450.00
35	БАРАА МАТЕРИАЛ	80,951,827.50	295,962,000.23
351	Түүхий эд материал	9,407,475.50	60,870,398.23
35110	Тусгай зориулалттай материал	9,407,475.50	55,870,398.23
35130	Эм боох материал	00.00	5,000,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,944,000.00	14,623,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,879,000.00	29,000.00
354	Хангамжийн материал	54,671,352.00	219,389,102.00
35410	Бичиг хэргийн материал	840,100.00	1,448,150.00
35420	Аж ахуйн материал	38,563,952.00	58,140,352.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,726,200.00	6,864,500.00
35450	Барилгын засварын материал	1,000,000.00	22,556,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,541,100.00	130,380,100.00
35600	Мал амьтад	1,050,000.00	1,050,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,349,995,892.20</u>	<u>7,435,278,466.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,349,995,892.20	7,435,278,466.16
392	Биет хөрөнгө	7,349,803,392.05	7,435,278,466.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	548,228,618.13	548,228,618.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-334,722,510.90	-386,872,997.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,850,000.00	88,644,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,281,249.85	-49,687,083.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,140,515.00	297,421,135.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-35,093,722.96	-34,661,251.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,491,900.00	11,077,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,594,523.40	-6,718,868.49
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	800,000.00	800,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,219,621,327.13	10,941,481,337.95
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,120,636,961.10	-3,974,433,623.98
393	Биет бус хөрөнгө	192,500.15	00.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-577,499.85	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,431,780,990.95</u>	<u>7,737,506,916.39</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>19,520,374.00</u>	<u>9,042,644.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,520,374.00	9,042,644.00
413	Өглөг	19,520,374.00	9,042,644.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	225,899.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,434,470.00	10,000.00
4136	Бусад өглөг	85,904.00	8,816,745.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	85,904.00	8,816,745.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,412,260,616.95	7,728,464,272.39
51	Засгийн газрын хувь оролцоо	7,412,260,616.95	7,728,464,272.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,216,853,052.00	2,216,853,052.00
51101	Өмч: - төрийн	2,216,853,052.00	2,216,853,052.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,193,522,251.36	5,509,725,906.80
51210	Өмнөх үеийн үр дүн	5,193,522,251.36	5,212,956,721.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	296,769,185.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,885,313.59	1,885,313.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,431,780,990.95	7,737,506,916.39

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	432,323,891.00	1,884,325,916.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	231,349,891.00	1,208,170,316.50
120	Нийтлэг татварын бус орлого	231,349,891.00	1,208,170,316.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	231,349,891.00	1,208,170,316.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,607,000.00	12,790,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	226,742,891.00	1,195,379,816.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	200,974,000.00	676,155,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,310,000.00	45,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,310,000.00	45,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	172,664,000.00	564,122,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	172,664,000.00	564,122,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	26,000,000.00	67,033,600.00
1330	Төсвийн захирагчдаас	26,000,000.00	67,033,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	721,910,839.02	1,508,990,023.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	721,910,839.02	1,508,990,023.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,324,138.02	1,478,813,940.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112,351,015.00	285,852,548.00
210101	Үндсэн цалин	112,351,015.00	285,852,548.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,291,297.00	41,304,094.43
210201	Тэтгэврийн даатгал	1,275,855.00	28,904,694.43
210202	Тэтгэмжийн даатгал	178,442.00	2,920,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	499,638.00	2,766,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	30,669.00	584,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	306,693.00	6,128,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,310,000.00	26,114,355.00
210301	Гэрэл, цахилгаан	26,000,000.00	25,995,083.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	119,272.00
210304	Байрны түрээс	1,310,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,178,200.51	18,507,569.81

210401	Бичиг хэрэг	618,910.00	1,513,150.00
210402	Тээвэр, шатахуун	4,570,182.00	14,815,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	369,008.51	821,919.81
210404	Ном, хэвлэл	31,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,000.00	1,125,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	273,600.00	232,000.00
2105	Нормативт зардал	6,615,000.00	2,584,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,615,000.00	2,584,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,097,295.90	15,585,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,251,480.00	438,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	364,600.00	994,300.00
210604	Урсгал засвар	10,481,215.90	14,152,300.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	808,500.00
210701	Гадаад албан томилолт	00.00	808,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,818,150.00	87,826,075.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,108,150.00	86,784,475.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	260,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	227,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	304,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	159,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	548,663,179.61	1,000,231,398.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,877,000.00	18,937,863.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	544,786,179.61	981,293,535.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,586,701.00	30,176,083.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,586,701.00	21,373,420.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,386,701.00	984,040.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	12,685,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	7,703,880.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	8,802,662.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	22,553.78
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-289,586,948.02	375,335,892.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	78,566,707.39
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	78,566,707.39
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-78,566,707.39
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-289,586,948.02	296,769,185.44

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	394,470,032.00	689,096,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,768,000.00	12,940,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,768,000.00	12,940,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,768,000.00	12,940,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,768,000.00	12,940,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,702,032.00	676,155,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,810,000.00	45,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,810,000.00	45,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	379,234,400.00	631,155,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	260,494,500.00	564,122,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	118,739,900.00	67,033,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,657,632.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,657,632.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	394,105,311.50	689,460,820.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,105,311.50	689,460,820.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,967,949.51	659,284,737.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,456,626.75	287,387,360.68
210101	Үндсэн цалин	208,495,596.75	261,323,500.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,400,000.00	10,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,561,030.00	16,063,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,070,773.25	39,429,100.00
210201	Тэтгэврийн даатгал	34,070,773.25	27,029,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,920,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,766,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	584,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,128,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,310,000.00	26,114,355.00
210301	Гэрэл, цахилгаан	50,000,000.00	25,995,083.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	119,272.00
210304	Байрны түрээс	1,310,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,195,699.51	22,143,069.54
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	2,099,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,495,000.00	14,744,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,699.51	993,619.54
210404	Ном, хэвлэл	200,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	1,125,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	3,180,450.00
2105	Нормативт зардал	4,000,000.00	6,137,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	6,137,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,641,700.00	127,582,936.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,085,000.00	33,644,000.00
210602	Тавилга	00.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,641,700.00	3,914,000.00
210604	Урсгал засвар	17,915,000.00	85,024,936.00
2107	Томилолт, зочны зардал	124,000.00	808,500.00
210701	Гадаад албан томилолт	00.00	808,500.00
210702	Дотоод албан томилолт	124,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,169,150.00	149,682,416.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,309,150.00	148,640,816.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	260,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	227,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	304,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	159,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,137,361.99	30,176,083.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,787,811.50	21,373,420.50
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,657,632.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,465,795.00	364,720.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,971,900.00	12,685,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,692,484.50	8,323,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	8,802,662.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	22,553.78
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,349,550.49	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	364,720.50	-364,720.50
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	364,720.50	-364,720.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	364,720.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	364,720.50	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	00.00	6,408,655,986.91	8,625,509,038.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,216,853,052.00	00.00	6,408,655,986.91	8,625,509,038.91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-289,586,948.02	-289,586,948.02
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,193,522,251.36	7,412,260,616.95
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,193,522,251.36	7,412,260,616.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	19,434,470.00	19,434,470.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,212,956,721.36	7,431,695,086.95
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	296,769,185.44	296,769,185.44
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	7,728,464,272.39

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	637,155,600.00	637,133,046.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,155,600.00	637,133,046.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	616,146,900.00	616,124,346.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,237,400.00	287,237,360.68
210101	Үндсэн цалин	261,173,500.00	261,173,500.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,000,000.00	10,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,063,900.00	16,063,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,429,100.00	39,429,100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,029,700.00	27,029,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,920,700.00	2,920,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,766,500.00	2,766,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	584,200.00	584,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,128,000.00	6,128,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,120,000.00	26,114,355.00
210301	Гэрэл, цахилгаан	26,000,000.00	25,995,083.00

210303	Цэвэр, бохир ус	120,000.00	119,272.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
		22,144,100.00	22,143,069.54
210401	Бичиг хэрэг	2,100,000.00	2,099,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,744,000.00	14,744,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	994,200.00	993,619.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,125,500.00	1,125,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,180,400.00	3,180,450.00
2105	Норматив зардал	6,140,000.00	6,137,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,140,000.00	6,137,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
		127,584,400.00	127,582,936.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,644,000.00	33,644,000.00
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,914,000.00	3,914,000.00
210604	Урсгал засвар	85,026,400.00	85,024,936.00
2107	Томилолт, зочны зардал	808,500.00	808,500.00
210701	Гадаад албан томилолт	808,500.00	808,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		106,683,400.00	106,672,025.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,641,000.00	105,630,425.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,300.00	227,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	304,500.00	304,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	159,600.00	159,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21008700.00	21008700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,008,700.00	21,008,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,685,500.00	12,685,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,323,200.00	8,323,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	637,155,600.00	637,133,046.22
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
		631,155,600.00	631,133,046.22
132001	Орон нутгийн төсвөөс	564,122,000.00	564,104,363.22
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	67,033,600.0	67028683.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
		6,000,000.00	6,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	6,000,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	45.00	45.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	33.00	33.00
620004	Гэрээт ажилтан	07.00	07.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,010,391.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,010,391.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,010,391.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,010,391.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,010,391.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43010391.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,010,391.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,219,891.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,790,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:


АУДИТОР:



Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



А.ЦЭЭНЯМ 2020.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Б.МӨНХБАТ 2020.02.25